# ЦУСНЫ  БАНКНЫ 2019 ОНЫ ТАЙЛАН

- А.Шинэжил
- Ч.Уламбаяр

# 1.2019 ОНЫ УРИА

- Аюлгүй цус цусан бүтээгдэхүүн хаана ч хэнд ч

# 2.ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

- БСНЭ-ийн даргын удирдлага дор ажилладаг.
- Мэс заслын тасагт харъяалагддаг.
- Нэг их эмч,нэг бага эмчийн орон тоотоогоор ажилладаг.

# 3.Ажлын төлөвлөгөө

Батлав

Дарга..................Б.Батбаатар

Цусны банкны 2019 онд хийх ажлын төлөвлөгөө

| Д/Д | Хэрэгжүүлэх үйл ажиллагаа | Хамтран ажиллах нэгж,байгууллага | Хариуцагч эзэн | Хугацаа |
| --- | --- | --- | --- | --- |
| 1. | Цус цусан бүтээгдэхүүний тухай ойлголт сургалт | БСНЭ-ийн тасгууд | А.Шинэжил Ч.Уламбаяр | 2019 он |
| 2. | Цус цусан бүтээгдэхүүний тухай ойлголт сургалт | Алтай ,Үенч сумын эрүүл мэндийн төв | А.Шинэжил Ч.Уламбаяр | 2019 он |
| 3. | Цусны донорын өдөр 2019 оны 6 сарын 14 | БСНЭ, Улаан загалмайн хороо | А.Шинэжил Ч.Уламбаяр | 2019 он |
| 4. | Цусны салбар банкыг батламжлуулах | БСНЭ захиргаа, Засаг даргын тамгын газар | А.Шинэжил Ч.Уламбаяр | 2019 он |
| 5. | Хамтын ажиллагааг өргөжүүлэх | БСНЭ, Улаан загалмайн хороо | А.Шинэжил Ч.Уламбаяр | 2019 он |

Төлөвлөгөө боловсруулсан:..................А.Шинэжил

# ХОВД БОЭТ-ИЙН ЦУСНЫ САЛБАР БАНКТАЙ ХАМТРАН БАРУУН 3 СУМЫН ЭМЧ АЖИЛЧДАД ДОНОРЫН ТУХАЙ ОЙЛГОЛТ СЭДВЭЭР СУРГАЛТ ХИЙВ.






# СУРГАЛТ ХИЙЖ БАЙГАА НЬ






# УЛААН ЗАГАЛМАЙН ХОРООТОЙ ХАМТРАН ЦУСНЫ ДОНОРЫН БОЛОХЫН АЧ ХОЛБОГДОЛ СЭДВЭЭР ЭМЧ АЖИЛЧДАД СУРГАЛТ ХИЙВ.





# МИНЖИТ БУЛГАН СУРГУУЛИЙН СУРАГЧДАД ДОНОР ГЭЖ ЮУ ВЭ СЭДВЭЭР ХИЧЭЭЛ ЗААВ.







# 2019.06.14 ДОНОРЫН БАЯР
# ХАМГИЙН ОЛОН УДАА ЦУСАА БЭЛЭГЛЭСЭН ДОНОРУУДАА УРАМШУУЛАВ.






# 2019.06.14 ДОНОРЫН БАЯР





# ЦУСНЫ ДОНОРЫН ДЭЛХИЙН ӨДӨР

- Цусны донорын өдрийг БСНЭ-ийн захиргаа,Булган сумын ЗДТГ,Улаан загалмайн хороотой хамтран зохион байгуулсан.Хамгийн олон удаа цусаа бэлэглэсэн нийт 8 донорт хүндэтгэл үзүүлсэн.

# 4.1.ДОНОР УРАМШУУЛАЛТ,АЛДАРШУУЛАЛТЫН ТАЛААР

- 2019 онд цусаа бэлэглэсэн доноруудаа урамшуулсан.
- Улаан загалмайн хүндэт медалиар Д.Батболд,Т.Даваахүү,Г.Цэцэгмаа
- Засаг даргын өргөмжлөлөөр
- М.Болдбаатар,С.Оюунгэрэл,Э.Гэрэлмаа
- Байгуулагын хүндэт өргөмжлөлөөр
- Д.Энхболд,Ц.Чинтөгс,Да.Энхболд нарыг шагнасан.

# ДОНОРЫН ХҮЛЭЭН АВАЛТ





# 2019.06.14-НЫ 1000 ДОНОРЫН ЧУУЛГАН УБ ХОТОД ТӨРИЙН ОРДОНД ХАМГИЙН ОЛОН БУЮУ 33 УДАА ЦУСАА БЭЛЭГЛЭСЭН Г.АРИУНБИЛЭГИЙН ХАМТ ОРОЛЦОВ.



# 4.2.ЦУС,СИЙВЭН ЦУГЛУУЛАЛТ/ЭХНИЙ 11 САРЫН БАЙДЛААР/

- 12 удаа 22 нэгж цус цуглуулсан.

# 4.3.ЛАБОРАТОРИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА/ЭХНИЙ 11 САРЫН БАЙДЛААР

- НИЙТ  100 ДОНОРТ КАССЕТАН ОНОШЛУУРААР 100% ХАМРУУЛСАН.
- 840 ХҮНД РЕЗУС БҮЛЭГ ҮЗСЭН.ҮҮНИЙ 15 СӨРӨГ БАЙСАН.30 ХҮНД КЕЛЛ БҮЛЭГ ҮЗСЭН.сөрөг 1.7%
- ЦУСНЫ ХУВИЙН ТОХИРОО ЦУС ЦУСАН БҮТЭЭГДЭХҮҮН БҮРТ ХИЙСЭН.

# 4.4.ЦУС ЦУСАН БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛДВЭРЛЭЛ/ЭХНИЙ 11 САРЫН БАЙДЛААР/

- 12 удаа 22 нэгж цус цусан бүтээгдэхүүн цуглуулсан.Нийт 8.8 литр
- ДУБ 19 нэгж 5720 гр
- УЭӨ 1 нэгж 230 гр
- ДЦ 2 нэгж 800 гр
- ХШС 22 нэгж 5880 гр

# 5.Энэ онд анх удаа БСНЭ-ийн дэргэд цус сэлбэлтийг зохицуулах зөвлөлтэй болсон.

ХОВД АЙМГИЙН
БУЛГАН СУМЫН НЭГДСЭН ЭМНЭЛГИЙН ДАРГЫН
ТУШААЛ

2019 оны 02 сарын 01 өдөр Дугаар А/20 Бүрэнхайрхан

Ажлын хэсэг байгуулах тухай

Эрүүл мэндийн тухай Монгол улсын хуулийн 36 дугаар зүйлийн 36.1 дэх хэсэг, Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/03 тоот тушаалыг үндэслэн ТУШААХ нь:

1.Байгууллагын цус сэлбэлтийг зохицуулах зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

Багийн ахлагч Б.Түмэнбаяр /эмчилгээ эрхэлсэн орлогч дарга/
Нарийн бичгийн дарга А.Шинэжил /трансфузлогич их эмч/
П.Мөнхнаран /эх барих эмэгтэйчүүдийн эмч/
Э.Мөнхжаргал /эм найруулагч/
Ч.Уламбаяр /цусны бага эмч/
С.Наранчимэг /лаборант/
Б.Эрдэнэчимэг /ахлах сувилагч/

2.Цус сэлбэлтийг зохицуулах зөвлөл нь цусны аюулгүй байдлыг хангах болон цус, цусан бүтээгдэхүүний зохистой хэрэглээг хэвшүүлэх талаар анхаарч ажиллахыг багийн дарга, гишүүдэд үүрэг болгосугай.

3.Цус сэлбэлтийг зохицуулах зөвлөлийн журмыг нэгдүгээр хавсралтаар баталсугай.

4.Энэхүү тушаалын биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг дотоод хяналт, аудитын багийн ахлагч /Г.Бямбажав/-д үүрэг болгосугай.

5.Энэ тушаал гарсантай холбогдуулан байгууллагын даргын 2016 оны 16/А тоот тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА Б.БАТБААТАР

Цус сэлбэлтийг зохицуулах зөвлөлийн ажиллах журам

1.Цус сэлбэлтийг зохицуулах зөвлөл нь хурал хийж ажлын төлөвлөгөө гаргана.

2. ЦСЗЗ нь жилд 2 удаа , шаардлагатай тохиолдолд тухайн үед зарлаж хуралдана
3. Эмнэлэгийн тасаг нэгжүүдэд шаардлагатай ЦЦБ-ий хэрэглээг бүртгэж хэрэгцээг улирал ,жилээр цусны бага эмч гаргана.

4. Цус сэлбэх үйл ажиллагааг цусны эмч, бага эмч бүрэн баримтжуулан ажиллана.

5. Лабораторийн чанарын гадаад хяналтыг лаборант хариуцан хийлгэнэ.

6. Эмнэлэгт хийгдэж байгаа цус сэлбэлттэй холбоотой үйл ажиллагаанд цусны эмч, цусны бага эмч дүн шинжилгээ хийж улирал жилээр статистик мэдээ гаргаж баримтжуулна.

7. ЦЦБ-ий зохистой хэрэглээ, аюулгүй цус сэлбэлтийн талаар цусны эмч эмч мэргэжилтэнд сургалт явуулна.

8.Цусны эмч Алтай ,Үенч сумдад ЦЦБ-ий хэрэглээ ,аюулгүй цус сэлбэлтийн талаар мэргэжил арга зүйн зөвөлгөөг өгнө.

9. Цус сэлбэлтийг орлох эмийн нөөцийг ЭЭО ,эм зүйч бүрдүүлж ажиллана.

10. Цусны нөөц бүтээгдэхүүн хадгалалт , тээвэрлэлт ,аюулгүй байдлыг цусны эмч ,бага эмч хариуцан ажиллана.

# ЦУС СЭЛБЭЛТИЙГ ЗОХИЦУУЛАХ ЗӨВЛӨЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ БАТЛУУЛАН АЖИЛЛАСАН.

Батлав

Дарга Б.Батбаатар

2019.02.04

БСНЭ-ийн Цус сэлбэлтийг зохицуулах зөвлөлийн 2019 оны ажлын төлөвлөгөө

| № | Хийгдэх ажил | хугацаа | Хариуцах эзэн | Биелэлт |
|---|---|---|---|---|
| 1 | Эмнэлэг тасаг нэгжүүдэд шаардлагатай ЦЦБ-ний хэрэглээг бүртгэн улирал жилээр тооцож гаргана. | Улирал бүр | Ч.Уламбаяр | |
| 2 | ЦЦБ-ний зохистой хэрэглээнд эмнэл зүйн сайн дадлыг нэвтрүүлэх | Тухай бүр | А.Шинэжил | |
| 3 | Цус сэлбэх үйл ажиллагааг бүрэн баримтжуулж хэвших | байнгын | Ч.Уламбаяр | |
| 4 | Цус сэлбэх үйл ажиллагаанд хяналт үнэлгээ хийх | Улирал бүр | Б.Түмэнбаяр П.Мөнхнаран | |
| 5 | Лаборторийн оношилгооны чанар ,аюулгүй байдлыг хангаж чанарын гадаад үнэлгээнд хамрагдах | Жилд нэг удаа | Г.Наранчимэг | |
| 6 | Эмнэлэгт хийгдэж байгаа цус сэлбэлттэй холбоотой үйл ажиллагаанд дүн шинжилгээ хийж жил , улирлаар статистик мэдээллийг нэгтгэн мэдээллэх | Улирал бүр | Ч.Уламбаяр | |
| 7 | ЦЦБ-ний зохистой хэрэглээнд ,аюулгүй цус сэлбэлтийн талаар эмч нарт сургалт хийх | Улирал бүр | А.Шинэжил | |

# 2019 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

| | | | | |
|---|---|---|---|---|
| 8 | Алтай ,Үенч сумдад цусны донорыг элсүүлэх ,цусны бүлэг хувийн тохироог тодорхойлох оношлуур ,цусны хүүдийн нөөцийг бүрдүүлэх , мэргэжил арга зүйн зөвөлгөө өгөх | Жилд нэг удаа | А.Шинэжил Ч.Уламбаяр | |
| 9 | Цус сэлбэлтийг орлох эмийн нөөц хангамжийг бүрдүүлэх | Улирал бүр | Э.Мөнхжаргал | |
| 10 | Нөөц бүтээгдэхүүний хадгалалт ,тээвэрлэлтийн аюулгүй байдалд хяналт хийх | Улирал бүр | Б.Түмэнбаяр П.Мөнхнаран Б.Эрдэнэчимэг | |
| 11 | ЦЦБ хадгалах зориулалтын (+2-оос +8хэм ) хөргөгчтэй болох | 2019 онд | Б.Түмэнбаяр | |
| 12 | Цусаа өгсөн донорт урамшуулал олгох (10000төг) | Тухай бүр | Ч.Уламбаяр | |

Төлөвлөгөө боловсруулсан: Б. Түмэнбаяр

А. Шинэжил

Б. Эрдэнэчимэг

П. Мөнхнаран

Э. Мөнхжаргал

Ч.Уламбаяр

Г. Наранчимэг

# ХУРЛЫН ПРОТОКОЛ

Цус сэлбэлтийг зохицуулах зөвлөлийн хурлын протокол

Цус сэлбэлтийг зохицуулах зөвлөлийн хурал 2019 оны 2сарын 4нд 9:00 цагт Б.Түмэнбаяр эмчийн өрөөнд 100% ирцтэй хурал эхэлсэн.

Цус сэлбэлтийг зохицуулах зөвлөлд дараах хүмүүс хамаарна.

ЦСЗЗ дарга: Б.Түмэнбаяр / эмчилгээ эрхэлсэн орлогч/

Нарийн бичгийн дарга: А Шинэжил /трансфузилогич их эмч/

Гишүүд : П Мөнхнаран /эмэгтэйчүүдийн их эмч/

Б Эрдэнэчимэг /Ахлах сувилагч/

Ч Уламбаяр /Цусны бага эмч/

Г Нарантуяа /Лаборант/

Э Мөнхжаргал / Эм найруулагч/

Хурлыг ЦСЗЗ дарга Б Түмэнбаяр удирдаж тус хурлаар ЦСЗЗ байгуулагдсан тушаал , ажлын төлөвлөгөө ,ажиллах журмыг танилцуулсан . Ажлын төлөвлөгөөг танилцуулахад гишүүд дараах саналыг гаргасан.

А.Шинэжил - Цусаа өгсөн донорт цусаа өгөх бүрт урамшуулал(10000төг ) өгөх хэрэгтэй,донорыг урамшуулж байж донорын идэвхи нэмэгдэнэ гэж бодож байна .

ЦЦБ-ийг хадгалах зориулалтын хөргөгчтэй болмоор байна гэж санал гаргасан .

Тус саналыг хэлэлцэж 2019 оны ажлын төлөвлөгөөндөө оруулан ажиллахаар болсон.

Тэмдэглэл хөтөлсөн : Э Мөнхжаргал

Хянасан: Б Түмэнбаяр

2019он 2сарын 4

# 9.Тоног төхөөрөмжийн ашиглалт

- Центрифуг
- 2018 онд Ховд БОЭТ цусны салбар банкнаас шилжиж ирсэн.



- Гүн хөлдөөгч
- 2018 онд УБ хот ЦССҮТ –өөс шилжүүлэн авсан.



- Хуруу шилний центрифуг
- 2017 онд БСНЭ-ийн дотоод захиалгаар ирсэн.



- Гагнагч
- 2015 онд УБ хот ЦССҮТ-өөс ирсэн.



- Хөргөгч
- 2019 онд БСНЭ-ээс санхүүжилтийг шийдэж БНХАУ-аас худалдан авсан.



- Цус цусан бүтээгдэхүүн зөөвөрлөх сав
- 2019 онд ХОВД БОЭТ-ийн Цусны салбар банкнаас манайд шинэ байранд орсонтой холбоотойгоор бэлэглэсэн.



- Цус цусан бүтээгдэхүүн тээвэрлэх сав
- 2019 онд БСНЭ-ээс цусны төвд авч өгсөн.



- Тарианы тэргэнцэр
- 2019 онд БСНЭ-ээс авч өгсөн.



# 10.СУМДЫН ЦУСНЫ АЮУЛГҮЙ БАЙДАЛ
# ХОВД ЦУСНЫ САЛБАР БАНКТАЙ ХАМТРАН АЛТАЙ,ҮЕНЧ СУМДЫН ИХ ЭМЧ,ДУНД МЭРГЭЖИЛТНҮҮДЭД СУРГАЛТ ХИЙСЭН.






# 10.Манай цусны төв Ховд аймгийн баруун 3 суманд дуудагдан ажилладаг билээ.

- Алтай суманд дуудлагаар очиж ДЦ-1 нэгж цуглуулсан.
- 70 мл цус нярайд сэлбэсэн.

# 11.БАРИМТЖУУЛАЛТЫН ТАЛААР ХИЙСЭН АЖИЛ



Улсын нэгдсэн бүртгэлийн 2016 оны 01 р сарын 22-ны одрийн 3603 дугаарт бүртгэв
Монгол Улсын Хууль зүйн яам

МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНД, СПОРТЫН САЙДЫН ТУШААЛ

2016 оны 01 сарын 06 өдөр Дугаар 02

Журам батлах тухай

Донорын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.4.2 дахь хэсэг, 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэг, 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсгийг үндэслэн ТУШААХ нь:

1. Цусны донор сонгох эрүүл мэндийн шалгуур үзүүлэлтийг нэгдүгээр, Донорын эрүүл мэндийн картыг хоёрдугаар, Донороос шинжилгээний сорьц авах, ийлдсийн сан бүрдүүлэх журмыг гуравдугаар, Цусны донор болон донороос цуглуулсан цусны нэгж, үйлдвэрлэсэн цус, цусан бүтээгдэхүүнд шинжилгээ хийх журмыг дөрөвдүгээр, Цусны албаны хог хаягдлын ангилал, устгал, аюулгүй ажиллагааны журмыг тавдугаар, Цус цусан бүтээгдэхүүн үйлдвэрлэх, хадгалах, тээвэрлэх, нөөц бүрдүүлэх, ханган нийлүүлэх, захиалах, олгох журмыг зургаадугаар, Цус сэлбэлттэй холбоотой урвал хүндрэлийн мэдээллийг хүлээн авч бүртгэх, шалтгааныг тодруулах, эргэн мэдээлэх журмыг долоодугаар хавсралтаар тус тус батлсугай.

2. Батлагдсан журмыг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахыг эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлдэг эрүүл мэндийн байгууллагуудын дарга, захирал нарт үүрэг болгосугай.

3. Журмын хэрэгжилтийн явцад мэргэжил арга зүйгээр хангаж ажиллахыг Эрүүл мэндийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /О.Баяр/, Цус, сэлбэлт судлалын үндэсний төв /Н.Эрдэнэбаяр/-д, хэрэгжилтэд хяналт тавихыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар /Э.Оюунсүрэн/-т тус тус үүрэг болгосугай.

4. Энэ тушаал батлагдан гарсантай холбогдуулан Эрүүл мэндийн сайдын 2010 оны "Цусны аюулгүй байдлыг хангах талаарх заавар журмыг шинэчлэн батлах тухай" 377 дугаар тушаалын 1, 2, 3, 4, 11 дүгээр хавсралт, Эрүүл мэнд, спортын сайдын 2015 оны "Журам батлах тухай" 407 дугаар тушаалын 3, 4,5, 6, 7, 8, 9 дүгээр хавсралтыг тус тус хүчингүй болгосонд тооцсугай.

САЙДЫН ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ Ц.ОЮУНБААТАР

001
ЭРҮҮЛ МЭНД, СПОРТЫН ЯАМ
ХУУЛБАР ҮНЭН

081928



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН ТУШААЛ

2017 оны 01 сарын 02 өдөр Дугаар А/03 Улаанбаатар хот

Заавар батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэг, Эрүүл мэндийн тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Зонхилон тохиолдох өвчний үед цус, цусан бүтээгдэхүүн сэлбэх зааврыг нэгдүгээр, цус сэлбэх үйл ажиллагаанд мөрдөх аргачлалыг хоёрдугаар, цус сэлбэх үйл ажиллагааг үнэлэх хяналтын хуудсыг гуравдугаар хавсралтаар тус тус батлсугай.

2. Батлагдсан зааврыг мөрдөж хэрэгжүүлж ажиллахыг цус, цусан бүтээгдэхүүн сэлбэх тусламж, үйлчилгээ үзүүлдэг төр, хувийн хэвшлийн бүх эрүүл мэндийн байгууллагын дарга, захирал нарт үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эмнэлгийн тусламжийн газар /Я.Буянжаргал/, Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар /Б.Баярт/, мэргэжил аргазүйн удирдлагаар хангаж ажиллахыг Цус сэлбэлт, судлалын үндэсний төв /Н.Эрдэнэбаяр/-д тус тус үүрэг болгосугай.

4. Энэхүү тушаал батлагдсантай холбогдуулан Эрүүл мэндийн сайдын 2010 оны 51 дүгээр тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

САЙД А.ЦОГЦЭЦЭГ

# ЭРҮҮЛ МЭНД,СПОРТЫН САЙДЫН ТУШААЛ А/01,А/02,А/03 ТООТ ТУШААЛУУДЫГ ӨДӨР ТУТМЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНДАА МӨРДЛӨГ БОЛГОН АЖИЛЛАСАН.


МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНД, СПОРТЫН САЙДЫН ТУШААЛ

2016 оны 01 сарын 06 өдөр Дугаар 01 Улаанбаатар хот

Журам батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийг үндэслэн ТУШААХ нь:

1. Цусны салбар төвийн үйл ажиллагааны дүрмийг нэгдүгээр, Цусны аюулгүй байдлыг хангах, хяналт, үнэлгээ хийх журмыг хоёрдугаар, Цусны албаны үйл ажиллагаанд мөрдөгдөх хяналтын жишиг хуудсуудыг гуравдугаар, Донорт сургалт, сурталчилгаа хийх, элсүүлэх, бүртгэх, хадлаглах журмыг дөрөвдүгээр, Цусны албаны үндсэн үйл ажиллагааны статистикийн мэдээ, тайлан гаргах, мэдээлэх журмыг тавдугаар, Цусны албаны үйл ажиллагаанд цахим сүлжээг хэрэгжүүлэх, мэдээллийн нууцлал, аюулгүй байдлыг хангах журмыг зургаадугаар, Нууцын баталгааны хуудсыг долоодугаар хавсралтаар тус тус батлацугай.

2. Батлагдсан журам, хяналтын хуудсыг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахыг, төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төв, бүсийн оношилгоо эмчилгээний төв, нэгдсэн эмнэлэг болон эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлдэг хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагын дарга захирал нарт, биелэлтэд хяналт тавихыг аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газрын дарга нарт үүрэг болгосугай.

3. Холбогдох журмын хэрэгжилтийн явцад мэргэжил аргазүйгээр хангаж ажиллахыг Эрүүл мэндийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /О.Баяр/, Цус, сэлбэлт судлалын үндэсний төв /Н.Эрдэнэбаяр/-д, хэрэгжилтэд нь хяналт тавихыг Хяналт, үнэлгээ дотоод аудитын газар /Э.Оюунсүрэн/-т үүрэг болгосугай.

4. Энэ тушаал батлагдан гарсантай холбогдуулан Эрүүл мэндийн сайдын 2008 оны "Дүрэм батлах тухай" 266 дугаар тушаалын 1 дүгээр хавсралт, 2010 оны "Цусны аюулгүй байдлыг хангах талаарх заавар журмыг шинэчлэн батлах тухай" 377 дугаар тушаалын 5 дугаар хавсралт, Эрүүл мэнд, спортын сайдын 2015 оны "Журам батлах тухай" 407 дугаар тушаалын 1, 2, 10, 11, 12 дугаар хавсралтуудыг тус тус хүчингүй болгосонд тооцсугай.

САЙДЫН ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ Ц.ОЮУНБААТАР

- Эрүүл мэнд,спортын сайдын тушаал А/01,А/02,А/03 тоот тушаалуудыг өдөр тутмын үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажилласан.



- Анхаарал хандуулсанд баярлалаа.